



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/155

Хэрлэн сум

Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг
ангилалт хийх, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх,
хээлтүүлэгч худалдан авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр хуралдааны “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.6.1.3 заалт, Мал үржүүлэг технологийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх, 3.2.6.2 заалт, Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийхэд шаардагдах 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн төсвийг зарцуулсугай.

2.Үржлийн малд үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, хээлтүүлэгч худалдан авах ажлын төсвийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Үржлийн малд үзлэг ангилалт хийж, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулж, 2025 оны 06 дугаар сарын 30-ны дотор тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөрт)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Баярхүү)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



D:\My Documents\Захирамж-2025

231010543




مفتیں

۴ ۳۰ ۶۵۰

بعضی بعضی کلام بعضی و

(Handwritten signature)



БАТАЛГААЖСАН ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛД ҮЗЛЭГ АНГИЛАЛТ
ХИЙЖ, ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, БҮРТГЭЛЖҮҮЛЭХ, ХЭЭЛТҮҮЛЭГЧ
ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТӨСВИЙН ХУВААРЬ

№	Сумын нэр	Үүлдэр, омгийн нэр	Ангилалтанд хамруулах малын тоо	Нэгж үнэ	Ангилалтанд шаардагдах зардал /төг/
1	Галшар	Галшар үүлдрийн адуу	2000	2500	5.000.000
		Галшарын улаан омгийн ямаа	3500	1500	5.250.000
2	Хэрлэн	Тал нутгийн цагаан үүлдрийн хонь	200	1500	300.000
3	Дадал	Дадалын ухаа үүлдрийн үхэр	2500	2500	6.250.000
4		Бог малын хээлтүүлэгч	15	550000	8.200.000
НИЙТ ЗАРДАЛ			8265		25.000.000

Тайлбар: ХХААХҮСайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ний өдрийн А/68 тушаалаар батлагдсан “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг тариф”-аар тооцсон болно